МОНГОЛЫН
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО

## АГУУЛГА


**МАЛЧДЫН ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО ........ 3**

САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ ........ 3

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН ХЗХ ........ 6

СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 8

СУРГАЛТ, ОРОЛЦОГЧИД ........ 9

БОЛЗОЛТ УРАЛДААН ........ 10

ПРОГРАМЫН СУРГАЛТ ........ 11

ХАМТЫН АЖИЛЛАГАА ........ 12

ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ ........ 15

САЙН ТУРШЛАГА ........ 16

СЕРТИФИКАТТАЙ СУРГАЛТ ........ 18

## ХҮСНЭГТ

Хүснэгт № 1. Төслийн хүрээнд байгуулагдсан ХЗХ мэдээлэл ....................................................................6
Хүснэгт № 2. Төслийн хүрээнд байгуулагдсан ХЗХ мэдээлэл (үргэлжлэл) ............................................7
Хүснэгт № 3. ХЗХ-ний зохиосон сургалт, оролцогчдийн мэдээл ...........................................................9
Хүснэгт № 4. ХЗХ-ний ахисан түвшиний сургалт, оролцогчдийн мэдээл.......................................... 18

## ГРАФИК

График № 1. Хот, орон нутгийн ХЗХ ..........................................................................................3
График № 2. Байгуулагдсан, хүчингүй, түдгэлзүүлсэн ХЗХ.....................................................................3
График № 3. Төсөл эхлэх үед болон Одоогийн ХЗХ орон нутагт ...........................................................4
График № 4. Төсөл эхлэх үед болон Одоогийн ХЗХ орон нутагт ...........................................................4
График № 5. ХЗХ хөрөнгийн хэмжээ, нийт зээл, ХЗХ тоо..........................................................................5

Монгол улсын 2019 оны жилийн эцсийн статистик мэдээгээр нийт 271 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаагийн 102 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. 2017 оноос хойш улсын хэмжээнд ХЗХ-дын тоо 24-р буурсан болович харин төсөл хэрэгжсэнээр орон нутагт өсөлттэй, харин УБ хотод огцом бууралттай байна.

*График № 1. Хот, орон нутгийн ХЗХ*




Төсөл хэрэгжих хугацаанд салбарын хэмжээнд нийт 46 ХЗХ байгуулагдаж, 11 ХЗХ сэргээгдэж, 46 ХЗХ шинэ хүсэлтийг түтгэлзүүлэн, 56 ХЗХ татан буугдсан байна.

*График № 2. Байгуулагдсан, хүчингүй, түдгэлзүүлсэн ХЗХ*

| Он | Шинээр олгосон | Хүчингүй болгосон | Түдгэлзүүлсэн | Сэргээсэн | ТЗ-ийн хугацаа сунгасан | ХЗХ-дын тоо |
|---|---|---|---|---|---|---|
| 2017 он | 17 | 8 | 21 | 4 | 54 | 290 |
| 2018 он | 18 | 29 | 19 | 7 | 100 | 279 |
| 2019он | 11 | 19 | 6 | - | 29 | 271 |

ХЗХ-дын нийт гишүүдийн тоо 2019 оны эцсийн байдлаар 70,121-д хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.3 хувиар буюу 8,240-өөр өссөн үзүүлэлт юм.

Нийт гишүүдийн 51.9 хувь буюу 36,380 нь эмэгтэй гишүүд байна. Нийт гишүүдийн 63.6 хувь буюу 44,634 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд 21 аймагт тархалттай байна. Орхон, Увс, Баян-Өлгий, Завхан аймгуудад ХЗХ ихээр төвлөрсөн. Төслийн зорилтот аймгууд Ховд, Говь-Алтай, Увс, Архангай, Баянхонгор аймгуудад өсөлттэй, Баян-Өлгий Завхан аймгуудад өрсөлдөөний зарчмаар цэгцэрч байна. Сэлэнгэ, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна. Тус аймгуудад дөнгөж дундын сангийн эхлэл суурь тавигдаж байгаа билээ.

*График № 3. Төсөл эхлэх үед болон Одоогийн ХЗХ орон нутагт*

2017 он - төсөл эхлэхэд




2019 он - Одоо




ХЗХ-дын гишүүд, 36.4 хувь буюу 25,487 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүд байна. Сүүлийн жилүүдэд хоршоологчдын хөдөлгөөн нэмэгдэж, салбарын нэг хүнд өсч, санхүүгийн мэдлэг боловсрол, хандлага өөрчлөгдөж байгаа илрэл бол салбарын өсөлт юм. НАМЭМ төслийн оруулж буй оролцоо нөлөөлөл (гишүүдийн тоо, орон нутаг дахь ХЗХ-дын тоогоор харьцуулвал) дундажаар 23 хувийг эзэлж байна.

*График № 4. Төсөл эхлэх үед болон Одоогийн ХЗХ орон нутагт*



ХЗХ-ны салбарын тоо үзүүлэлт өсөлтөөс гадна чанарын үзүүлэлт өсөлттэй байна. ХЗХ-дын нийт активын банкны салбарт эзлэх хувь 0.6 хувьтай байгаа бол 2019 онд гишүүдийн тоо 13.3 хувиар, нийт активын хэмжээ 13.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр буурсан байна. Нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.8 хувиар өссөн байгаа бол нийт орлого 25.4 хувиар, нийт зардал 20.5 хувиар, нийт цэвэр орлого 56.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна

*График № 5. ХЗХ хөрөнгийн хэмжээ, нийт зээл, ХЗХ тоо*




Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 102 ХЗХ-ны нийт актив 28,469,680.7 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 13.0 хувийг, нийт зээлийн үлдэгдэл салбарын 14.6 хувийг, нийт чанаргүй зээлийн үлдэгдэл 9.4 хувийг, нийт хадгаламжийн үлдэгдэл 11.0 хувийг тус тус эзэлж байна. Орон нутгийн хоршоодын нийт орлого өмнөх оны мөн үеэс 32.3 хувиар, нийт зардал 29.7 хувиар, цэвэр орлого 40.6 хувиар тус тус өссөн байна.

*Хүснэгт № 1. Төслийн хүрээнд байгуулагдсан ХЗХ мэдээлэл*

| # | Хоршооны нэр | Аймаг/Сум | Он | Тусгай зөвшөөрөл авсан | ХНХ доод хэмжээ мян ₮ | Хоршоо өмч сая ₮ | Гишүүн тоо | Нийт актив сая ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | БУГАТ ДАМЫСЫ ХЗХ | БӨ, БУГАТ | 2015 | ТЗ АВСАН 2016.03.23 | 50.0 | 9.4 | 290 | 171.4 |
| 2 | БУЛГАН ДАМЫСЫ ХЗХ | БӨ, БУЛГАН | 2015 | ТЗ АВСАН 2016.03.11 | 30.0 | 20.0 | 581 | 183.6 |
| 3 | ДЭЛҮҮН БУЯН ХЗХ | БӨ, ДЭЛҮҮН | 2015 | ТЗ АВСАН 2016.03.23 | 50.0 | 15.0 | 244 | 134.8 |
| 4 | АУХАТ ХОРЫ ХЗХ | БӨ, УЛААНХУС | 2015 | ТЗ АВСАН 2016.03.23 | 50.0 | 36.1 | 582 | 327.0 |
| 5 | МАЛЧНЫ ХӨГЖИЛ ХЗХ | БӨ, ЦЭНГЭЛ | 2015 | ТЗ АВСАН 2008.06.12 | 30.0 | 159.5 | 2211 | 2,368.7 |
| 6 | ХУНДЫМУРА ХЗХ | БӨ, ӨЛГИЙ | 2017 | ТЗ АВСАН 2015.05.20 | 50.0 | 34.5 | 469 | 597.1 |
| 7 | МӨНХИЙН БУЯН ӨГӨӨЖ ХЗХ | ХОВД, ДӨРГӨН | 2017 | ТЗ АВСАН 2017.10.27 | 200.0 | 45.0 | 175 | 350.0 |
| 8 | ХӨГЖИЛ ТЭМҮҮЛЭХ СУТАЙ ХЗХ | ХОВД, ДАРВИ | 2018 | ТЗ АВСАН 2018.06.29 | 100.0 | 20.0 | 191 | 130.0 |
| 9 | ҮЕНЧ АРВИЖИН ДЭЛГЭРЭХ ХЗХ | ХОВД, ҮЕНЧ | 2018 | ТЗ АВСАН 2019.06.26 | 200.0 | 5.8 | 29 | 6.0 |
| 10 | ХААНГАЛ ТАМГА ХЗХ | ХОВД, ЭРДЭНЭБҮРЭН | 2018 | ТЗ АВСАН 2018.11.14 | 100.0 | 12.0 | 120 | 80.0 |
| 11 | ИХЭС НУУРЫН ХИШИГ ХЗХ | ГОВЬ-АЛТАЙ ДАРИВ | 2017 | ТЗ АВСАН 2018.02.28 | 100.0 | 20.0 | 182 | 135.0 |
| 12 | ВАНГИЙН ИВЭЭЛ ХЗХ | ГОВЬ-АЛТАЙ БАЯНУУЛ | 2017 | ТЗ АВСАН 2018.01.24 | 100.0 | 26.7 | 242 | 113.3 |
| 13 | ХӨГЖИН ДЭЛГЭРЭХ ХЗХ | ГОВЬ-АЛТАЙ ДЭЛГЭР | 2017 | ТЗ АВСАН 2018.01.24 | 150.0 | 24.9 | 166 | 112.0 |
| 14 | ДЭВЖИН УНДРАХ ЭРДЭНЭ ХЗХ | ГОВЬ-АЛТАЙ ЭРДЭНЭ | 2017 | ТЗ АВСАН 2018.02.07 | 100.0 | 15.0 | 133 | 58.0 |
| 15 | НОГООН ТӨГРӨГ ФИНАНС ХЗХ | УВС НАРАНБУЛАГ, УЛААНГОМ | 2017 | ТЗ АВСАН 2018.05.04 | 100.0 | 16.0 | 145 | 47.0 |
| 16 | АРВИН ХИШИГ ӨГӨӨЖ ХЗХ | УВС ТАРИАЛАН | 2017 | ТЗ АВСАН 2018.05.23 | 100.0 | 29.9 | 212 | 45.8 |
| 17 | ДАВСТ ӨРНӨН ДЭЛГЭРЭХ ХЗХ | УВС ДАВСТ | 2018 | ТЗ АВСАН 2019.05.08 | 100.0 | 11.4 | 114 | 56.5 |
| 18 | ТЭЛМЭН ТЭГШ ХЭМ ХЗХ | ЗАВХАН, ТЭЛМЭН | 2010 | СУНГАСАН 2017.11.08 | 35.0 | 15.0 | 292 | 94.2 |
| 19 | ЛҮН МЯНГАНЫ ОРГИЛ ХЗХ | ЗАВХАН ШИЛҮҮСТЭЙ | 2018 | ТЗ АВСАН 2019.08.10 | 100.0 | 2.1 | 21 | 2.1 |
| 20 | УРГАХ НАР УРАН МАНДАЛ ХЗХ | АРХАНГАЙ ТАРИАТ | 2018 | ТЗ АВСАН 2018.05.04 | 100.0 | 20.0 | 200 | 20.0 |
| 21 | ДӨРВӨН БОГДЫН БУЯН ХЗХ | БАЯНХОНГОР БОГД | 2017 | ТЗ АВСАН 2018.01.24 | 100.0 | 21.7 | 155 | 124.4 |

*Хүснэгт № 2. Төслийн хүрээнд байгуулагдсан ХЗХ мэдээлэл (үргэлжлэл)*

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | УУЛЫН ХААНЫ ХИШИГ ХЗХ | ТӨВ ӨНДӨРШИРЭЭТ | 2017 | ТЗ АВСАН 2018.01.24 | 100.0 | 17.3 | 173 | 34.4 |
| 23 | НОГООН АЛТ ФИНАНС ХЗХ | МБАНХ ТББ | 2017 | ТЗ АВСАН 2017.07.05 | 200.0 | 39.5 | 79 | 624.4 |
| 24 | ДУУТ НУУРЫН ХИШИГ ХЗХ | ХОВД, ДУУТ | 2018 | ТЗ БЭЛТГЭЛ | 100.0 | 2.0 | 20 | 2.0 |
| 25 | ТАВАНХАЙРХАНЫ ХИШИГ ХЗХ | ХОВД, МАНХАН | 2018 | ТЗ БЭЛТГЭЛ | 100.0 | 2.0 | 20 | 2.0 |
| 26 | ИХ УУЛСЫН БУЯН ХИШИГ ХЗХ | ЗАВХАН ИХ-УУЛ | 2018 | СЗХ ХЯНАЛТАНД | 100.0 | 2.0 | 20 | 2.0 |
| 27 | САНТ ОЧИР МАРГАЗ ХЗХ | ЗАВХАН САНТМАРГАЗ | 2019.8 | ТЗ БЭЛТГЭЛ | 100.0 | 2.0 | 20 | 2.0 |
| 28 | ДӨРВӨН УУЛЫН БУЯН ХИШИГ ХЗХ | ЗАВХАН ТЭС | 2019.8 | СЗХ ХЯНАЛТАНД | 100.0 | 2.0 | 20 | 2.0 |
| 29 | ЯРУУ САЯАР ДЭЛГЭРЭХ ХЗХ | ЗАВХАН ЯРУУ | 2019.8 | СЗХ ХЯНАЛТАНД | 100.0 | 2.0 | 20 | 2.0 |
| 30 | ЖИНСТ БОДЬ МӨНГӨН СҮРЭГ ХЗХ | БАЯНХОНГОР ЖИНСТ | 2019.8 | СЗХ ХЯНАЛТАНД | 100.0 | 2.0 | 20 | 2.0 |
| 31 | БАЯНЦАГААН ТАВАН ЭРДЭНИЙН БУЯН ХЗХ | БАЯНХОНГОР БАЯНЦАГААН | 2019.9 | СЗХ ХЯНАЛТАНД | 100.0 | 2.0 | 20 | 2.0 |
| 32 | ТЭНГЭРИЙН ОРГИЛГО ХЗХ | УВС ЦАГААНХАЙРХАН | 2019.9 | ТЗ БЭЛТГЭЛ | 100.0 | 2.4 | 24 | 2.4 |
| 33 | ЛИГИЙН ГОЛ АРВАЙН ҮНДЭС ХЗХ | БАЯНХОНГОР БАЯНЛИГ | 2019.10 | ТЗ БЭЛТГЭЛ | 200.0 | 4.8 | 24 | 4.8 |

**Сургалт, зөвлөгөө түгээх дараалал**




**1-р түвшин – Таниулах сургалт – 4 цаг**

Аймгийн нягтлан бодогч нар дундын санг ХЗХ шилжүүлэхийн ач тусыг таниулах, ерөнхий ойлголт, мэдээлэл өгөх сургалтыг бэлчээрийн гэрээний болон Малын эрүүл мэндийн сургалтын үеэр 4 цагийн сургалт хийсэн. Нийт сургалтын мэдээг сургалтын мэдээллийн сангаас харна уу.

**2-р түвшин – ХЗХ-ний хууль, ерөнхий ойлголтын сургалт, ХЗХ байгуулах дадлага ажил – 2 өдөр**

СБАХ тэргүүн нар болон ХЗХоршоо болохоор сонирхож буй СБАХ-д ХЗХ-ний хуулийн заалт, МХЗХҮХолбоо ТББ-ний боловсруулсан видео хичээл, сайн туршлага, онолын мэдлэгийг олгож байна. Сургалтын 2 дохь өдөр ХЗХ байгуулах бүх гишүүдийн хурал хийж, удирдлагуудыг сонгох дүрэм, журмуудаа батлах дадлага ажил хийх сургалт.

**3-р түвшин – МХЗХҮХ-ний ахисан түвшний сургалт - 2 өдөр**

Мэргэжлийн байгууллагаар ХЗХ-ний тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлага, зээлийн хороонд ахисан түвшний мэдлэг олгох, бизнес төлөвлөгөө боловсруулах зэрэг сургалтанд хамруулж байна. Хуулиар зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага болох МХЗХҮХолбоо ТББ-тай хамтран сургалтууд зохион байгуулж байна. 2 шатын гүнзгийрүүлсэн сургалт хагас жилийн хойш хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсан. Ахисан түвшний буюу ХЗХ удирдлагууд, аймгийн нябо нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг хавсралтаас харна уу.

**4-р түвшин – Онлайн сургалт - 10 цуврал**

Хадгаламж зээлийн хоршоод НАМЭМ, МБАНХ фэйсбүүк группээр зайны сургалт, зөвлөгөө өгөгдөж байна.

*Хүснэгт № 3. ХЗХ-ний зохиосон **с**ургалт, оролцогчдийн мэдээл*

| № | Аймаг, хот | Сум, дүүрэг | Хэлбэр | Он | Сар | Өдөр | Тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баянхонгор | Баянлиг | Танхимын сургалт | 2019 | 10 | | 2 |
| 2 | Баянхонгор | Жинст, Баянцагаан | Танхимын сургалт | 2019 | 8 | 4 | 2 |
| 3 | Баянхонгор | Богд Жинст | Зөвлөгөө үнэлгээ | 2019 | 10 | 23 | 2 |
| 4 | Говь-Алтай | Чандмань | Хамтарсан | 2019 | 10 | 10 | |
| 5 | Говь-Алтай | Эрдэнэ | Хамтарсан | 2019 | 6 | 16 | 2 |
| 6 | Говь-Алтай | Төгрөг | Танхимын сургалт | 2019 | 10 | 23 | 2 |
| 7 | Говь-Алтай | Тонхил | Хамтарсан | 2019 | 9 | 19 | 1 |
| 8 | Говь-Алтай | Жаргалан | Танхимын сургалт | 2019 | 4 | 4 | 2 |
| 9 | Говь-Алтай | Тонхил | Хамтарсан | 2019 | 1 | 25 | 2 |
| 10 | Говь-Алтай | Дарви | Танхимын сургалт | 2019 | 5 | 22 | 2 |
| 11 | Говь-Алтай | Эрдэнэ | Зөвлөгөө үнэлгээ | 2019 | 10 | 18 | 1 |
| 12 | Говь-Алтай | Дарви | Зөвлөгөө үнэлгээ | 2019 | 11 | 3 | 1 |
| 13 | Говь-Алтай | Баян-Уул | Зөвлөгөө үнэлгээ | 2019 | 11 | 4 | 1 |
| 14 | Говь-Алтай | Дэлгэр | Зөвлөгөө үнэлгээ | 2019 | 11 | 6 | 1 |
| 15 | Ховд | Дөргөн | Сургалт өдөрлөг | 2019 | 10 | 31 | 2 |
| 16 | Ховд | Дарви Үенч Эрдэнэбүрэн | Сургалт өдөрлөг | 2019 | 10 | 31 | 2 |
| 17 | Архангай | Тариат | Танхимын сургалт | 2019 | 8 | 20 | 1 |
| 18 | Архангай | Чулуут | Танхимын сургалт | 2019 | 11 | 12 | 2 |
| 19 | Архангай | ИХтамир | Танхимын сургалт | 2019 | 8 | 17 | |
| 20 | Архангай | Эрдэнэбулган | Танхимын сургалт | 2019 | 8 | 17 | |
| 21 | Завхан | Сантмаргаз Тэс Яруу | Үзүүлэх сургалт | 2019 | 8 | 6 | 2 |
| 22 | Увс | Давст | Туршлага судлах аялал | 2019 | 6 | 3 | 1 |
| 23 | Увс | Наранбулаг | Туршлага судлах аялал | 2019 | 6 | 3 | 1 |
| 24 | Увс | Тариалан | Туршлага судлах аялал | 2019 | | | |
| 25 | Увс | Наранбулаг | Танхимын сургалт | 2019 | 8 | 20 | 1 |
| 26 | Увс | Цагаанхайрхан | Танхимын сургалт | 2019 | 11 | 24 | 2 |
| 27 | Увс | Цагаан хайрхан | Танхимын сургалт | 2019 | 11 | 21 | 2 |
| 28 | Увс | Цагаан хайрхан | Танхимын сургалт | 2019 | 11 | 20 | 2 |
| 29 | Увс | Цагаан хайрхан Зүүнговь | Танхимын сургалт | 2019 | 9 | 21 | 2 |
| 30 | Увс | Тариалан | Зөвлөгөө үнэлгээ | 2019 | 9 | 23 | 1 |
| 31 | Увс | Өмнөговь | Зөвлөгөө үнэлгээ | 2019 | 9 | 24 | 1 |
| 32 | Увс | Давст | Зөвлөгөө үнэлгээ | 2019 | 9 | 25 | 1 |

# МАЛЧДЫН ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

## БОЛЗОЛТ УРАЛДААН

НАМЭМ төслийн хүрээнд байгуулагдсан бүх тусгай зөвшөөрлөө авсан, Санхүүгийн Зохицуулах Хороонд албан ёсоор хүсэлтээ хүргүүлсэн бүх Хадгаламж Зээлийн Хоршоодын дунд болзолт уралдааныг 2018 он 3 улирлаас 2019 оны 3 улирлын хугацаанд зохион байгуулав.

**Уралдаан зорилго:**

- ✓ Хоршоолох хөдөлгөөн үнэт зүйл мөн чанарыг таниулах, ХЗХ-ийн зорилго, үйл ажиллагаа сурталчлах, гишүүнчлэлээ нэмэгдүүлэх, Хувь нийлүүлсэн хөрөнгөө өсгөх хадгаламж татах
- ✓ Сайн туршлагуудыг сурталчлах, дэмжих, байгууллага, мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, малчдын хэрэгцээнд нийцсэн санхүүгийн үйлчилгээгээр хангах, өргөтгөх чанарыг сайжруулах үйл ажиллагааг дэмжин дэлгэрүүлэхэд
- ✓ ХЗХ-ийн Өрсөлдөх чадвар зах зээл эзлэх байр суурыг нэмэгдүүлэх, малчин гишүүдийн оролцоо нийгмийн идэвхи, санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд энэхүү болзолт уралдааны зорилго оршино.

Тус болзолт уралдаанд нийт 19 ХЗХ оролцож, түүнээс тооны 5 шалгуур, чанарын 3 шалгуур үзүүлэлтээр дүгнэж, хөгжлийн шатаар нь 3 үндсэн болон тусгай байрыг шалгаруулан урамшуулсан.

1. Мөнхийн буян өгөөж ХЗХ - 1 байр
2. Вангийн ивээл ХЗХ - 2 байр
3. Ихэс нуурийн хишиг ХЗХ - 3 байр
4. Баян-Өлгий аймгийн Хундымура ХЗХ - Тусгай байр

Тус уралдаанд шалгарсан хоршоодод туршлага судлах аялал, тохижилт, тоног төхөөрөмж зэрэг дэмжлэгийг хүртэв.


МОНГОЛЫН БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО

БАТЛАВ. МБАНХ ТББ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ГАНХУЯГ

ХЗХ ЧАДАВХИЖУУЛАХ, ГИШҮҮНЧЛЭЛЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ, АКТИВАА ӨСГӨХ
"ИДЭВХИТЭЙ ГИШҮҮН – ХУРИМТЛАЛТАЙ МАЛЧИН - ЧИНЭЭЛЭГ АМЬДРАЛ"
БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

УРАЛДААНЫ ЗОРИЛГО:
- ✓ Хоршоолох хөдөлгөөн үнэт зүйл мөн чанарыг таниулах, ХЗХ-ийн зорилго, үйл ажиллагаа сурталчлах, гишүүнчлэлээ нэмэгдүүлэх, Хувь нийлүүлсэн хөрөнгөө өсгөх хадгаламж татах
- ✓ Сайн туршлагуудыг сурталчлах, дэмжих, байгууллага, мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, малчдын хэрэгцээнд нийцсэн санхүүгийн үйлчилгээгээр хангах, өргөтгөх чанарыг сайжруулах үйл ажиллагааг дэмжин дэлгэрүүлэхэд энэхүү болзолт уралдааны зорилго оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ:
НАМЭМ төслийн хүрээнд байгуулагдсан бүх тусгай зөвшөөрлөө авсан, Санхүүгийн Зохицуулах Хороонд албан ёсоор хүсэлтээ хүргүүлсэн бүх Хадгаламж Зээлийн Хоршоодын дунд болзолт уралдааныг зохион байгуулна.

НЭГ. БОЛЗОЛТ УРАЛДААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
2018 оны 3 улирлын санхүү үйл ажиллагааны тайланг суурь үзүүлэлт болгон өсөлтөөр нийт 4 улирлдын дундаж үзүүлэлтээр шалгаруулна. Үүнд
- Гишүүний тооны өсөлт
- Хадгаламж ба хуримтлалын үзүүлэлт/гишүүний тоо
- Нийт хөрөнгийн өсөлт/гишүүний тоо
- Нийт цэвэр зээлийн тооны өсөлт/гишүүний тоо
- ДМШҮзүүлэлт хангасан байдал

ХОЁР. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ, ШАГНАЖ УРАМШУУЛАХ
Энэхүү болзолт уралдаан нь 2018 оны 09 дугаар сарын 30-аас 2019 оны 9 дугаар сарын 30–ний өдрийг хүртэл явагдах бөгөөд болзолын үзүүлэлтийг хангасан ХЗХ харьяа аймгийн бэлчээр ашиглагчдын холбоо (АБАХ)–оор уламжлуулан уралдааны шалгаруулалтанд оролцоно.
Шилдэг туршлага бүхий оролцогчдыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилж үйл ажиллагааны сайн туршлага арга зүйг нийтийн хүртээл болгоно.

Эрүүл бэлчээр
Эрүүл хүнс
Эрүүл монгол хүн

| Аймаг сум | Нэр | Гишүүн | Нийт хөрөнгө /мян.төгрөг/ |
|---|---|---|---|
| Ховд Дөргөн | Мөнхийн буян өгөөж | **162** | **318,541.60** |
| Ховд Дарви | Хөгжил Тэмүүлэх Сутай | 29 | 73,729.67 |
| Баянхонгор Богд | Дөрвөн Богдын Буян | 154 | 114,491.72 |
| Говь-Алтай Дарви | Ихэс Нуурын Хишиг | 150 | **123,376.61** |
| Говь-Алтай Баян-Уул | Вангийн ивээл | **202** | 80,174.44 |
| Говь-Алтай Дэлгэр | Хөгжин Дэлгэрэх | 107 | 98,296.46 |
| Говь-Алтай Эрдэнэ | Дэвжин Ундрах Эрдэнэ | 106 | 47,070.26 |
| Увс Наранбулаг | Ногоон төгрөг | 145 | 45,398.51 |
| Увс Тариалан | Арвин хишиг өгөөж | 202 | 40,287.56 |
| Төв Өндөрширээт | Уулын хааны хишиг | 173 | 34,455.67 |
| БӨ Цэнгэл | Малчин хөгжил | **998** | **2,199,448.65** |
| БӨ Дэлүүн | Дэлүүн-Буян | 23 | 58,066.12 |
| БӨ Улаанхус | Аухат хоры | 22 | 336,735.78 |
| БӨ Бугат | Бугат дамысы | 22 | 134,800.53 |
| БӨ Алтай | Алтайн өндөр уулс | - | - |

## МАЛЧДЫН ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

### ПРОГРАМЫН СУРГАЛТ

Монголын Хадгаламж Зээлийн Хоршоодын Холбоо (MOCCU) ТББ-той хамтын ажиллагааны нэг чухал хэсэг болох тус холбоонд гишүүнчлэлтэй ХЗХ-дуудад Интерактивийн Би Ай ХХК-ийн Спинел бичил санхүүгийн программыг 5 дахин хямдруулсан хөнгөлөлттэй үнээр буюу жилийн 230 мянган төгрөгөөр суурилуулж байна. НАМЭМ төслийн зүгээс тус гишүүнчлэлээр бүртгүүлэх, програм суулгах, баланс шилжүүлэх 10 өдрийн сургалтанд шинэ ХЗХ хамрагдахад санхүүгийн дэмжлэг үзүүлж, холбогдож өгч байна.

Улаанбаатар хотноо 2019 оны 5 дугаар сард Хадгаламж зээлийн хоршоонд ашигладаг санхүүгийн "Спинел-6.0" программын сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд Баянхонгор, Говь-Алтай, Увс, Ховд аймгийн 6 сумын ХЗХ болон Ногоон Алт Финанс ХЗХ-ны нягтлан бодогч нар оролцов (Зураг 11). Сургалтанд хамрагдсан ХЗХ-дын нэрсийг жагсаалтаар үзүүлэв.

- Дөрвөн богдын буян – Баянхонгорын Богд сум
- Хөгжин дэлгэрэх – Говь-Алтайн Дэлгэр сум
- Дэвжин Ундрах Эрдэнэ - Говь-Алтайн Эрдэнэ сум
- Уулын хааны хишиг – Төв Өндөрширээт сум
- Арвин хишиг өгөөж - Увс Тариалан сум
- Ногоон төгрөг - Увс Наранбулаг сум




*Зураг 1. ХЗХ-ны "Спинел-6.0" программын сургалтын үеэр*

**Санхүүгийн зохицуулах хороо**

2000 оны эхэн үед олон ХЗХ дампуурсан явдал нь нийт ард иргэдийн дунд ХЗХ талаар буруу ойлголттой, бодиттой мэдээлэлгүй, ХЗХ-ийн талаар зөв нэгдсэн ойлголтгүй байна. ХЗХ-ны талаар нийтийг хамарсан зөв мэдээлэл түгээх, сурталчлах, Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны чиглэл зорилгын талаар таниун мэдүүлэх шаардлагатай их байна.

Малчид, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт, мөн Баян-Өлгийн аймгийн ХЗХ үйл ажиллагаа, төслийн хөрөнгө оруулалтанд гэнэтийн шалгалтыг СЗХ хамтран 2019.06.09-17 дуустал 9 хоног хугацаанд нэр бүхий 11 сумуудад зохион байгуулав. Аялалын бүрэлдэхүүнд СЗХ-ны ХЗХГ-ын ахлах референт, улсын байцаагч Л.Энхбаяр, ХШЗГ-ын хянан шалгагч, улсын байцаагч А.Золзаяа, ХЗХГ-ын ахлах зөвлөх Э.Эрхэмбаяр, ХШЗГ-ын хянан шалгагч, улсын байцаагч Ж.Дэмчигсүрэн, МБАНХ-ны хоршооны зөвлөх Н.Баасанхүү нар оролцов.

Орон нутаг дахт төрийн албаны ажилтаны мэдлэг мэдээлэл дутмаг байгааг холбогдох газарт уламжилж, ард иргэдэд чирэгдэл учруулахыг зогсоож, учирч болох эрсдэлээс сэрэмжлүүлэн, МХЗХҮХолбоо ТББ болон Санхүүгийн зохицуулах хороонд хандан залруулав.

**Хадгаламж зээлийн хоршоодын холбоо (MOCCU)**

МХЗХҮХ нь СЗХ-ны 2018.06.29 өдрийн 245 дугаар тогтоолын хавсралт "ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага"-ын 2.1 дүгээр зүйлийн 2.1.12-т заасан "ХЗХ-ны ТЗ, ХЗ, гүйцэтгэх захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд Монголын Хадгаламж Зээлийн Хоршоодын Үндэсний Холбооны сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх" гэсэн шаардлагын дагуу анхан шатны сургалт "Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагаа" "Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа" "Гүйцэтгэх захиралын үйл ажиллагаа" "Зээлийн хорооны үйл ажиллагаа" "Нягтлан бодох бүртгэлийн онцлог" сургалтанд хоршоо бүрээс тус бүр 5 хүн хамруулж байна. Хүснэгт № 4 харна уу.






Мөн жил бүр зохион байгуулдаг Хуримтлалын өдөрлөг, Хоршоологч гишүүдийн үзэсгэлэн экспо, дотоод болон гадаад туршлага судлах аялал, салбарын шинэ жил, спортын арга хэмжээ, Үндэсний форум зэрэг ХЗХ идэвхитэй оролцож байна. Хамтын ажиллагааны хүрээнд 2020 онд Үндэсний форум, Төв болон баруун бүсийн чуулга уулзалтыг хамтран зохион байгуулахаар тохиролцоод байна.

**Бусад донор байгууллагууд**

Хадгаламж Зээлийн Хоршоо байгуулан ажиллахад голлох хоёр асуудал байна. Шинээр үүсгэн байгуулагдсан хоршоодын актив бага гишүүд олон учраас эх үүсвэр дутагдаж байгааг шийдэх зорилгоор ХЗХ-дод гишүүдийн тоо, активын хэмжээ, бизнес төлөвлөгөөг үндэслэн хэмжээ, хүү, хугацааг тогтоон богино хугацааны шаардлагатай эх үүсвэрээр хангахыг судалж бусад донор (Ифад, WWF, TNC, Mercy corps) байгууллагатай хамтран ажиллаж байна.

Байгуулагдаад тодорхой хугацаанд хөгжиж буй 1 тэрбумаас дээш активтай ХЗХ-дод найдвартай зээлдэгч буюу түншийн харилцааг өргөжүүлэх асуудал чухал байна. Эдгээр хоршоонуудад шинэ бүтээгдэхүүн гаргах, Анхан шатны хоршоотойгоо хамтран ажиллах, зэргэлдээ сумддаа салбараа нээх зэрэг арга хэмжээ авч зохицуулж байна.

Дундын сангийн үйл ажиллагааг ХЗХоршоо болгосноор сангийн хөрөнгө зарцуулалтыг илүү ил тод, нээлттэй болгох, хяналтыг сайжруулах, төрөөс үзүүлдэг дэмжлэг туслалцаанд хамрагдах боломжийг илүү болгох, малчид даацаас хэтэрсэн малаа борлуулж мөнгөн малтай болох зэрэг олон талын ач холбогдолтой.





Шинээр үүсгэн байгуулагдаж буй ХЗХ-нуудад тусгай зөвшөөрлөө авсан тохиолдол зөөврийн компьютер, хэвлэх төхөөрөмж, ХЗХ-ны санхүүгийн программ, хяналтын камер, интернэтийн төхөөрөмж, мэдээллийн самбар, шүүгээ, ширээ сандал, мөнгөний сейф, гарын авлага, сургалтын материал зэргийг үе шаттайгаар тодорхой болзол даалгаврыг хангасны дараа олгож байна.

**НОГООН АЛТ-МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ДУНДЫН САНГААС ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНД ШИЛЖИН АЖИЛЛАЖ БУЙ ХОРШООД**



# МАЛЧДЫН ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

МОНГОЛЫН БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО

## ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

### Гадаад туршлага

Дэлхийн хэмжээний үйлчилгээг орон нутагт урианд дор Төслийн болон хоршоодынхоо оролцоон дээр тулгуурлан орон нутгийн хоршоодын 12 төлөөлөл болох Вангийн ивээл, Ихэс нуурын хишиг, Дөрвөн богдын буян, Ногоон төгрөг, Мөнхийн буян өгөөж Ногоон алт финанс ХЗХ-д Малчдын ногоон алт дундын хоршоо, МБУНДХ, Баян-өлгий Говь-Алтай болон Ховдын АБАХ-ууд туршлага хуримтлуулах аялалд оролцов. Зээлийн хоршоодын үйл ажиллагааг хэрхэн яаж аялал жуулчлалтай холбож амжилтанд хүрч иргэдээ ядуурлаас гаргахад амжилт олж байгааг үзэж бахархаж өөрийн орны онцлогт хэрхэн ашиглаж болох сайхан санааг багийнхан маань олж авч байна. Бид хүр хорхойн, Луугийн нүд жимсний, ЛИ ба МО нутгийн уугуул үндэстэний аж ахуй гар урлал, могойн аж ахуй,цайны болон ямааны аж ахуй эрхлэж байгаа хоршоодыг үзлээ. Хятад нөхөд зээлийн хоршоогоо Хоршоологчдынхоо банканд нэгтгэж хөгжлийн дараагийн шатанд орж байгаа тухай танилцуулгыг албаны болон хоршооны удирдлагаас дэлгэрэнгүй мэдээлэл авлаа.







2017 оноос бидний зочилсон хоршоо Хятадын засгийн газрын "Ядуурлыг бууруулах" бодлогын хүрээнд зээлийн хоршооны хэлбэрээр хоршиж засгийн газраас 4,6 сая юаны зээл аван, 170 гаруй га газар луугын жимс тариалж эхэлсэн. Тус мужид ийм маягаар үүсгэн байгуулагдсан 11 хоршоо бий. Хоршоонд тус тосгонд төрсөн хүн бүр гишүүн болж, жил бүр ноогдол ашгаас хүртнэ. Одоогоор 2200 гаруй гишүүнтэй, үүнээс 80 гишүүнийг сонгон төлөөлөгчөөр ажиллуулдаг, ТУЗ-ын 7 гишүүнтэй. Оны эцэст ноогдол ашиг хувиарлахаас гадна Засгийн газрын зээлийн хүүний 10 хувийг жил бүр хоршооны гишүүдэд хуваарилахаар Засгийн газартай 8 жилийн гэрээ байгуулсан. Тариалангийн талбай дээр өдөрт хоршооны 40 гишүүн ажилладаг. Хураасан жимсыг нь байнга худалдан авдаг хамтрагч байгууллагатай. Тус байгууллага нь эдгээр 40 ажилтныг цалинжуулан ажиллуулаад, буцаад хураасан жимсийг худалдан авна. Ингэснээр хоршооны гишүүд нь байнгын тогтмол хувь ашиг хүртэж, мөн ажлын байраар хангагдах боломжийг олгож өгсөн байна.

### Дотоод туршлага

Шинэ болон хуучин хоршоод харилцан бие биенээс туршлага солилцох үүднээс жил бүр хоршоо бүрээс 2 төлөөлийг дотоод туршлага судлах аялалд оролцуулах уламжлал тогтоод байна. 2018 онд Баян-Өлгийн Цэнгэл сум, 2019 Ховд аймгийн Дөргөн сумын ХЗХ-д бусад хоршоодыг найрсагаар хүлээн авч, туршлагаа судлахаас гадна дотоод аялалтай хослуулан гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлж байна.

# МАЛЧДЫН ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО

## САЙН ТУРШЛАГА

Дундын санг бүрдүүлэн ажиллуулсан сумдын СБАХ-ууд 3-5 жилд малчид харилцан итгэлцэл буй болж зээлийн үйл ажиллагаа явуулах итгэлцэл туршлага хуримтлагдсан нь хөгжлийн дараагийн шатанд үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх нөхцөл бүрэлдсэн.

Дундын сангаас Хадгаламж зээлийн хоршоонд шилжих үйл ажиллагааны явцад өнгөрсөн 3 жилийн хугацаанд **САЙН ТУРШЛАГУУД** буй болсон.

### 1. Сургалтын хөтөлбөр

Сургалтын материал, хөтөлбөрөө малчны хөгжлийн суурь тулгуур байгууллагууд болох Малчны буюу Маркетингийн хоршоо, Малчны ТББ буюу СБАХ, АБАХ, Дундын сан буюу Хадгаламж зээлийн хоршоонуудын харилцан уялдаатай хөгжих боломжийг харуулсан итгэл үнэмшил төрж, хандлагыг өөрчлөх чиглэлээр бэлтгэж явуулсан үр дүнтэй үр нөлөөтэй байж чадсан.

### 2. Төслийн боловсон хүчний нөөцийг түшиглэсэн

Дундын сангаас Хадгаламж зээлийн хоршоонд шилжих урьдчилсан нөхцөл байдал ХЗХ-ны анхан шатны мэдээллийг гишүүд малчиддаа нэгэн утгатай хүргэх шаардлага ойлголтоо нэгтгэх үндсэн дээр аймгуудын СБАХ-ын тэргүүнүүдэд Малчны тулгын гурван чулуу болсон байгууллагуудын харилцан уялдаа хөгжлийн чиг хандлагын тухай нэгдсэн цэгцтэй мэдээлэл ойлголт өгсөн. Дундын сангийн хүрээнд зээл олгох туршлагатай байсан нь мэргэжлийн санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэхэд үр дүнтэй байна.

### 3. Бүсчилсэн буюу нэгдсэн сургалт

Анхан шатны сургалтыг бүсчилэн нэгдсэн байдлаар хийсэн цаг хугацаа хөрөнгө санхүү үр ашигтай зарцуулах оролцогчид бие биенээс суралцах боломж өгсөн сайн шийдэл болсон.

### 4. МБАНХ-ны дэргэд хоршоо байгуулсан

Нэг талаасаа сургалтын түшиц бааз болгох нөгөө талаасаа байгууллагынхаа ажилчдын амьдралын чанрыг дээшлүүлэх зорилгоор МБАНХ-ны дэргэд Ногоон алт финанс ХЗХ байгуулан МБАНХ-ийн бусад бүх ажилтань зөвлөхүүд өөрсдийнхөө ХЗХ-ны мэдлэг дадлагыг практик амьдрал дээр сайжруулан дээшлүүлж уг хоршооныхоо туршлага сургамжийг шинэ хоршоодынхаа үйл ажиллагаанд ашигласан нь илүү хурдан илүү үр өгөөжтэй туслалцаа дэмжлэг үзүүлэх боломж бүрдсэн

### 5. Хандлагыг тодорхойлох

Зөв хандлагыг бий болгосноор илүү том амжилтанд хүрч чадна. Зөв хандлага биднийг илүү өндөрт хүргэж чадна. Өөрөөр хэлбэл ажилтнуудынхаа хандлагыг өөрчилж, байнга сургаж хөгжүүлж чаддаг байгууллагын үйл ажиллагаа зорилготой хүрч хөгжих боломжоо хадгалж үлддэг. Иймээс малчдаа өөрсдөө ямар хандлагатай вэ? гэдгээ тодорхойлох тестээр тодорхойлуулан сургалтанд оролцуулсан нь шинэ хоршоондоо итгэх итгэл үнэмшил нь дээшилж оролцоо нь нэмэгдсэн нь явцад тодорхой ажиглагдсан.

**6. Алтан хонх**

Сургалтын дараагийн тест буюу мэдлэг бататгах үйл ажиллагааг “Алтан хонх” хөгжөөнтэй тоглоом хэлбэрээр явуулдаг нь үр дүнтэй бөгөөд баг цагт ихээхэн мэдээлийг багцхан хүргэдэг сайн практик болсон.

**7. Анхан шатны сургалтыг өөрсдийн нөөц бололцоогоор зохион байгуулсан.**

Анхан шаттны сургалтыг төслийн зүгээс өөрсдийн хүч нөөцөөр зохион байгуулсан нь харьцангуй бага зардлаар хүмүүсээ нэг ойлголттой нэг чиглэлтэй болгосон төслийн хувьд сайн туршлага үргэжлүүлэн хэрэгжүүлэх практик болж чадсан. Зөвхөн сургалтанд оролцсон хүний сургалтын төлбөрийг МХЗХҮХ-д төлнө гэхэд л 601*90,000=54,090,000 төгрөг болох эдийн засгийн тооцоо гарч байгаа юм. Эндээс дүгнэлт хийгээд 6-8 дахин буюу нийт зардлын 16-20 хувиар л илүү үр дүнтэй хэрэглэгчиддээ ойртсон ажил болж чадсан.

**8. Салбарын хөгжилд оруулах хувь нэмэр, оролцоо**

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны мөрдөх журмын төсөл, ХЗХ хуулийн төсөл санал асуулга






*Хүснэгт № 4. ХЗХ-ний ахисан түвшиний **с**ургалт, оролцогчдийн мэдээл*

| № | Овог | Нэр | Сум | хүйс | албан тушаал | сургалтын он |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Н | Н.Батбаяр | Баян-Уул | эр | Хоршоо дарга | 2017 |
| 2 | Х | Х.Алимаа | Баян-Уул | эм | Нягтлан бодоч | 2017 |
| 3 | З | З.Дамдинсүрэн | Баян-Уул | эр | Хоршоо тэргүүлэгч | 2017 |
| 4 | Н | Н.Даариймаа | Баян-Уул | эм | Хоршоо тэргүүлэгч | 2017 |
| 5 | Б | Б.Мэндбаяр | Баян-Уул | эр | Хяналтын зөвлөл | 2017 |
| 6 | Г | Г.Адиймаа | Эрдэнэ | эм | Нягтлан бодоч | 2017 |
| 7 | Г | Г.Даш | Эрдэнэ | эр | Тэргүүлэгч | 2017 |
| 8 | С | С.Баярмагнай | Эрдэнэ | эр | Хяналтын зөвлөл | 2017 |
| 9 | Г | Г.Баяраа | Эрдэнэ | эр | Гүйцэтгэх захирал | 2017 |
| 10 | А | А.Батчимэг | Эрдэнэ | эм | Нягтлан бодоч | 2017 |
| 11 | Г | Г.Цэвээн | Дарив | эм | Хоршоо дарга | 2017 |
| 12 | Ч | Ч.Барс | Дарив | эр | Тэргүүлэгч | 2017 |
| 13 | Ш | Ш.Удвал | Дарив | эм | Хяналтын зөвлөл | 2017 |
| 14 | н. | Төмөрбаатар | Дарив | эр | Гүйцэтгэх захирал | 2017 |
| 15 | Д | Д.Нэргүй | Дарив | эм | Нягтлан бодоч | 2017 |
| 16 | Н | Н.Энхтайван | Дэлгэр | эр | Хоршоо дарга | 2017 |
| 17 | А | А.Энхжаргал | Дэлгэр | эм | Нягтлан бодоч | 2017 |
| 18 | Б | Б.Алтанцэцэг | Дэлгэр | эм | Гүйцэтгэх захирал | 2017 |
| 19 | Д | Д.Норжин | Дэлгэр | эм | Тэргүүлэгч | 2017 |
| 20 | Д | Д.Цэвэгмэд | Дэлгэр | эм | Тэргүүлэгч | 2017 |
| 21 | Н | Н.Батбаяр | Баян-Уул | эр | Гүйцэтгэх захирал | 2019 |
| 22 | н | Алимаа | Баян-Уул | эм | Нягтлан бодогч | 2019 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 23 | Ч | Ч.Оюунгэрэл | Тонхил | эм | Нягтлан бодогч | 2019 |
| 24 | Д | Д.Галбадрах | Тонхил | эр | Тэргүүлэгч | 2019 |
| 25 | Ш | Ш.Буянзаяа | Эрдэнэ | эм | Нягтлан бодогч | 2019 |
| 26 | н | Аварзэд | Дарив | эр | Тэргүүлэгч | 2019 |
| 27 | н | Төмөрбаатар | Дарив | эр | Гүйцэтгэх захирал | 2019 |
| 28 | Бизьяа | Эрдэнэмягмар | Яруу саяар дэлгэрэх | эр | Тэргүүлэгч | 2019 |
| 29 | Загдрагчаа | Отгонжаргал | Дөрвөн уулын хишиг буян | эр | Тэргүүлэгч | 2019 |
| 30 | Арьяа | Дамдинсүрэн | Лүн мянганы оргил | эм | Тэргүүлэгч | 2019 |
| 31 | Арьхад | Нямдорж | Сант очир маргаз | эр | Тэргүүлэгч | 2019 |
| 32 | Түдэвжамц | Пагмасүрэн | Яруу саяар дэлгэрэх | эм | Хяналтын зөвлөл | 2019 |
| 33 | Галиндэв | Алтанцэцэг | Дөрвөн уулын хишиг буян | эм | Хяналтын зөвлөл | 2019 |
| 34 | Лувсандагва | Батнасан | Лүн мянганы оргил | эр | Хяналтын зөвлөл | 2019 |
| 35 | Баатар | Долгорсүрэн | Сант очир маргаз | эм | Хяналтын зөвлөл | 2019 |
| 36 | Донёд | Баярсайхан | Яруу саяар дэлгэрэх | эр | Гүйцэтгэх захирал | 2019 |
| 37 | Янжиндлам | Эрдэнэ-Очир | Дөрвөн уулын хишиг буян | эр | Гүйцэтгэх захирал | 2019 |
| 38 | Цэдэндамба | Хашчулуун | Лүн мянганы оргил | эр | Гүйцэтгэх захирал | 2019 |
| 39 | Мөнх | Өнөржаргал | Сант очир маргаз | эм | Гүйцэтгэх захирал | 2019 |
| 40 | Мягмарсүрэн | Нямбат | Яруу саяар дэлгэрэх | эр | Зээлийн хороо | 2019 |
| 41 | Янжиндулам | Эрдэнэ-Очир | Дөрвөн уулын хишиг буян | эр | Зээлийн хороо | 2019 |
| 42 | Чимэдцэрэн | Бүрнээ | Лүн мянганы оргил | эм | Зээлийн хороо | 2019 |
| 43 | Баавгай | Туяа | Сант очир маргаз | эм | Зээлийн хороо | 2019 |
| 44 | Мягмарсүрэн | Нямбат | Яруу саяар дэлгэрэх | эр | Нягтлан бодогч | 2019 |
| 45 | Гэндэнжамц | Эрдэнэчулуун | Дөрвөн уулын хишиг буян | эр | Нягтлан бодогч | 2019 |
| 46 | Шагдаржав | Отгонтуяа | Лүн мянганы оргил | эм | Нягтлан бодогч | 2019 |
| 47 | С. | Молдир | Дэлүүн буян ХЗХ | эр | Нягтлан бодогч | 2019 |
| 48 | М. | Есенберди | Дэлүүн буян ХЗХ | эм | Гүйцэтгэх захирал | 2019 |
| 49 | | Жанерке | Аухат Хоры ХЗХ | эм | Нягтлан бодогч | 2019 |
| 50 | А | Жахсылых | Хундымура | эр | Гүйцэтгэх захирал | 2019 |
| 51 | | Ганаа | Дөрвөн Богдын Буян ХЗХ | эр | Тэргүүлэгч | 2018 |
| 52 | | Баттогоо | Дөрвөн Богдын Буян ХЗХ | эр | Гүйцэтгэх захирал | 2018 |
| 53 | | Очирхуяг | Дөрвөн Богдын Буян ХЗХ | эм | Нягтлан бодогч | 2018 |
| 54 | Д | Цогбадрах | Мөнхийн буян өгөөж | эр | Тэргүүлэгч | 2019 |
| 55 | | Билэгдэмбэрэл | Мөнхийн буян өгөөж | эр | Тэргүүлэгч | 2019 |
| 56 | | Оюуномин | Мөнхийн буян өгөөж | эм | Тэргүүлэгч | 2019 |
| 57 | | Энхзаяа | Мөнхийн буян өгөөж | эм | Хяналтын зөвлөл | 2019 |
| 58 | | Цэвэлмаа | Үенч арвижин ундрах | эм | Нягтлан бодогч | 2019 |

МОНГОЛЫН
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО

ЭРҮҮЛ БЭЛЧЭЭР ЭРҮҮЛ ХҮНС ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН